

ЖИНСТ УВС ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 4-р сарын 28-ны өдөр

Дугаар: 18/1

Улаанбаатар хот

Жинст Увс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын Соёмбо хурлын танхимд 14:00-с эхлэв.

Хурлын ирц: 55%

Тооллогын комиссын дарга Б.Мөнхзулын танилцуулснаар: “ҮЦТХТ-с 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөр тасалбар болгон авсан мэдээллээс саналын эрхтэй 1,665,938 ширхэг энгийн хувьцааны 916,720 ширхэг хувьцааг эзэмшигч 233 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож байгаа нь нийт хувьцаа эзэмшигчдийн 55% болж байгааг хуралд оролцогсод болон хурлын даргад мэдээллэв. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.13-ыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсон тухай хурлын дарга Ч.Ганхуягт мэдэгдэж, хурал хүчин төгөлдөрт тооцов. Итгэмжлэлээр оролцож буй иргэд: ...

Хурлын дарга Ч.Ганхуяг ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулав, хэлэлцэх асуудлыг бүгдийг танилцуулж хэлэлцүүлсний дараагаар санал хураалт явуулах, саналын хуудас хураахыг санал болгов . Хэлэлцэх асуудал, хурлын дэгтэй холбогдуулж санал байхгүй.

Хурлын дэг:

1. 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх)-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх тухай;
3. ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгон томилох тухай;
4. Жинст Увс ХК-д Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг нэгтгэх замаар хоёр компани нэгдэх тухай;
5. Жинст Увс ХК-д Ард Санхүүгийн Нэгдэл ХЗ-ийг нэгтгэж буйтай холбогдуулж компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай;
6. Жинст Увс ХК-ийн нэрийг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болгон өөрчлөн батлах тухай;
7. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх тухай;
8. Бусад асуудал.

ЖИНСТ УВС ХК

Хэлэлцсэн нь №1: Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ч.Ганхуяг: Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний гүйцэтгэл үр дүн, цаашдын зорилгын талаар танилцуулъя.

Өнөөдөр өглөөний Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шинэ бүтээгдэхүүнүүдээ танилцуулсан байгаа, өнөөдрийн хурлын дундуур та бүхний саналыг авч, тооллогын комисс саналын хуудсыг тоолж байх хугацаанд бид шинэ бүтээгдэхүүнээ танилцуулах болно.

Бид 2 жил гаруйн өмнө нэгэн зорилго дор нэгдэж, хамтын ажиллагаагаа эхлүүлсэн билээ. Өнгөрсөн хугацаанд манай гүйцэтгэх баг өмнөө тавьсан том зорилгынхоо төлөө зүтгэж, багагүй ажил хийлээ. Үүний үр дүнг бид 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр харж, Хуучнаар Хөрөнгө Оруулагч Үндэстэн одоо Жинст Увс ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхэн хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржээр чөлөөтэй арилжаалагддаг болжээ.

2017 онд бид өмнө нь санаачилж эхлүүлсэн зарим ажлаа зангидан нэгтгэж, эцсийн үр дүнг нь харлаа. Бид Монголын Хөрөнгийн Бирж дээр өөрийн хувьцаагаа арилждаг Монголын анхдагч санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болох зорилгодоо хүрч – 12 дугаар сарын 15-ны өдөр бидний хувьд түүхэн өдөр болж тэмдэглэгдэн үлдэх болно – энэ өдөр Хөрөнгө Оруулагч Үндэстнийг Жинст Увстай нийлүүлэх замаар хувьцааг нь олон нийтэд чөлөөтэй арилжаалж эхэлсэн. Харин одоо 2018 онд бид Ард Санхүүгийн Нэгдлийг хуучнаар Хөрөнгө Оруулагч Үндэстэн буюу Жинст Увс ХК-тэй нэгтгэх түүхэн шийдвэрийг энд гаргахаар хуран цуглаад байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн эрхэм зорилго. Ашиг болон эрсдэлийн хэтийн харьцааг тэнцвэртэй барьснаар хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн өндөр түвшинд хүргэх бодлогыг чиглэл болгон ажиллана. Алсын хараа. Бид хөрөнгө оруулагчид болох ард иргэдийнхээ санхүүгийн өгөөжийг дээдлэх бодлогыг баримталдаг Үндэсний хамгийн хүчирхэг санхүүгийн нэгдэл компани байхыг зорьж ажиллана зорилготой ажиладаг билээ.

Ард Санхүүгийн Нэгдэл, Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК нилээд өнөөдөр 3,000 хувьцаа эзэмшигчтэй. 3,000 хувьцаа эзэмшигчийг энэ жил 30 мянга болгох зорилт тавиад байна. Цаашлаад 300 мянга, гурван саяулаа хувьцаа эзэмшигч болох боломжтой гэж харж байна. Хоёр жилийн өмнө дэвшүүлсэн Хөрөнгө оруулагч үндэстэн болох зорилт руугаа бид дахин нэг алхам урагшиллаа. Хөрөнгийн бирж өнөөдөр түүхэнд байгаагүй идэвхитэй арилжаа явагдаж, компаниуд зөвхөн арилжааны банкуудаас санхүүгийн эх үүсвэрээ татах хандлагаас зайлсхийлж

улам олон байгууллага Монголын Хөрөнгийн Биржийг зориж байна. Энэ бол та бидний эхлүүлсэн ажлын үр дүн, бидний үүсгэсэн “хөрөнгө оруулалтын урсгалтай салшгүй холбоотой”.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулалттай Ард Кредит ББСБ ХХК нь хөрөнгийн зах зээл эрчимтэй хөгжиж хүрээгээ тэлж буй өнөө үед Ард Кредит ББСБ нь “Хувьцаагаа барьцаалсан зээл”-ийн үйлчилгээг санал болгож байна. Тодруулбал, Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй ТОП 20 компани буюу А самбарын компаниудын хувьцааг барьцаалан зээл авах боломжийг олгох төслийг эхлүүдээд байна. Ард аппликэйшнийг татан авч гар утсандаа суулгаснаар иргэд тус компаниас үзүүлж буй санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг авах боломжтой боллоо. Ард аппликэйшнийг ашигласнаар банкинд дугаарлах болон зээлийн судалгаа шаардлагагүй болно. Хувьцаагаа бүртгүүлээд, өргөдлөө өгөөд л таны зээл бүтэх боломжтой төслийг амжилттай эхлүүлээд байна.

Мөн Грэйп Сити компанитай хамтран ArdPay шинэ аппликэйшнийг гаргалаа. Үүгээр дамжуулж иргэд төлбөр тооцоо зэрэг санхүүгийн үйлчилгээг гар утаснаасаа авах бүрэн боломжтой болж байгаа юм. Мөн GoPay криптовалютын Монголын үндэсний дотооддоо хийсэн аппликэйшн танилцуулаад байна. Бид GoPay аппликэйшнээр дамжуулж биткойноор чөлөөтэй төлбөр тооцоо хийх, зээл авах боломжийг олгож буйгаараа онцлогтой” хэмээн гэв.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн Гүйцэтгэх захирал асан Б.Тамир: 2016 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагддаг Жинст Увс ХК-д нэгдэх шийдвэрийн дагуу 2017 оны гүйцэтгэх баг уйгагүй ажиллаа.

Өнгөрсөн хугацаанд бид 900 гаруй хувьцаа эзэмшигчтэй болж хувь нийлүүлэгчдийн цар хүрээгээ нэмэгдүүлсэн байна. Хаалттай хүрээнд хувьцаа эзэмшигч нараас татан төвлөрүүлсэн мөнгийг анхны 1 тэрбум төгрөгөөс 1.8 тэрбум болгож өсгөжээ. Бид хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтаар урт хугацаандаа арилжааны банк тэргүүтэй санхүүгийн нэгдэл байгуулахаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн бөгөөд ТУЗ-ийн шийдвэрээр богино хугацаанд хөрөнгөө өсгөх зорилгоор ЗГ-ын бонд, Монгол Шуудан ХК, Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Даатгал ХХК, Ард Актив ХЗХ нарт хөрөнгө оруулсан бөгөөд бидний хөрөнгө оруулалтын хэрэгжсэн болон хэрэгжээгүй олз нийт 0.9 тэрбум төгрөг болоод байна.

Үндсэн хөрөнгө оруулалт болох Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг тус компанийн жилийн тайлангаас та бүхэн сонирхоно уу. Хувьцаа эзэмшигч бүрийн гарын авлагат Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн жилийн тайлан, тэр дундаа санхүүгийн аудитлагдсан тайлан, дүгнэлт орсон байгаа болно.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн тогтоолоор хоёр компанийг нэгтгэх шийдвэр гарч, 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Увс аймгийн улсын бүртгэлийн газар Жинст Увс ХК-ийн дүрэмд компанийн нийт гаргасан хувьцааг 1,665,938 ширхэг, хувь нийлүүлсэн хөрөнгийг 1,665,938,000 төгрөг гэж бүртгүүлснээр Хөрөнгө Оруулагч

Үндэстэн ХК-ийн ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсон байгаа үүнтэй холбогдуулж Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн ТУЗ-ийн гишүүдээс өнөөдөр Жинст Увс ХК-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлж, та бүхэнд танилцуулж байгаа.

Мөн 2017 он хийгдсэн бидний хамгийн том ажлуудын нэг бол яах аргагүй Хөрөнгө Оруулагч Үндэстэн чуулган билээ. Монголын хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх, ард иргэдэд санхүүгийн боловсрол олгох, санхүүжилт эрэлхийлж буй бизнесүүдийг хөрөнгө оруулагчтай холбох, дэлхийн шилдэг хөрөнгө оруулагчдын туршлага, зах зээлийн чиг хандлагыг анхдагч эх үүсвэрээс нь түгээх Монголын хамгийн том Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулганыг бид 4 сарын 22-нд Корпорэйт Конвеншн центрт маш амжилттайгаар анхны удаагаа зохион байгуулсан билээ. Чуулганд 1,300 гаруй хүн оролцсоноос гадна УИХ-ийн гишүүд, Монголын томоохон компаниуд болох Монгол Шуудан, Монос, Юнител групп, Lend.mn, Сэлэнгэ пресс, Улаанбаатар принт г.м албан ёсоор ивээн тэтгэж, хамтран зохион байгуулсан билээ.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийг татан буулгах ажлын хүрээнд компанийн банкны дансуудыг хааж, татан буугдсан тухай сонинд зарлуулсан, мөн гааль, татварын лавлагааг авч, татварын шалгалт орсон байгаа бөгөөд татан буугдах ажиллагаа үндсэндээ дуусгавар шатруу орж байна.

Та бүхэн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай холбогдуулж асуух асуулт, тодруулах зүйл байвал асууна уу.

Асуулт, хариулт: байхгүй.

Хэлэлцсэн нь №2: ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх тухай.

Танилцуулсан нь: Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн Гүйцэтгэх захирал асан Б.Тамир: Жинст Увс ХК нь сүүлийн 10 гаруй жил идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй ба одоо үүрэг гүйцэтгэж байгаа Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ” гэх)-ийн гишүүд нь 2016 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон болно. Жинст Увс ХК-ийн компанийн дүрмийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил бөгөөд 2019 онд дуусгавар болно.

2017 оны 12 дугаар сард Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийг өөртөө нэгтгэх замаар хоёр компани нэгдсэн бөгөөд Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчид нь шинээр байгуулагдсан компанийн нийт 95 гаруй хувийг бүрдүүлж байна.

Татан буугдаж буй Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн зүгээс шинээр өөрчлөн байгуулагдсан Жинст Увс ХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, компанийн засаглалыг сайжруулах зэрэг шаардлагын хүрээнд хуучин ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-иас хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж байна.

Асуулт, хариулт: байхгүй.

Хэлэлцсэн нь №3. ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгон томилох тухай

Танилцуулсан нь: ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулав.

Ердийн гишүүнд нэр дэвшигч Ч.Ганхуяг №1

Боловсрол:

- Унгар Budapest University of Economic Sciences Эдийн засагч
- АНУ Stonier/ABA Мэргэжил дээшлүүлэх сургууль
- АНУ Shore Bank
- АНУ Бүтээлч манлайлалын төв Манлайлалын хөтөлбөр
- АНУ Харвард Кеннеди Их сургууль 21-р зууны Дэлхийн Манлайлал ба Олон нийтийн бодлого

Ажлын туршлага:

- Хас Банк ХХК Гүйцэтгэх захирал 1998 2009
- ТэнГэр Санхүүгийн Нэгдэл Гүйцэтгэх захирал 2009 2010
- Сангийн яам Сангийн Дэд сайд 2010 2012
- И Ай Ти ХХКТУЗ-ийн Дарга 2012 2014
- Ард Санхүүгийн Нэгдэл ХК Гүйцэтгэх захирал 2014 Одоо

Ердийн гишүүнд нэр дэвшигч А.Батболд №2

Боловсрол

- Монгол Отгонтэнгэр их сургууль Англи хэлний багш Бакалавр
- Монгол МУИС – Хууль зүйн сургууль Хуульч Бакалавр
- Япон Нагоя Их Сургууль Хууль Зүйн Магистр Магистр

Ажлын туршлага

- Ард Даатгал ХХК Үйл ажиллагаа хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал 2016 2018
- Ард Секюритиз (Монет Капитал) ҮЦК Гүйцэтгэх захирал 2014 2016
- Ард Санхүүгийн Нэгдэл (ИАйТи) ХХК Гүйцэтгэх захирал 2012 2014
- Монет Капитал ХХК Гүйцэтгэх захирал 2009 2012
- ХасБанк Тэнгэр Санхүүгийн Нэгдэл Үйл ажиллагаа эрхэлсэн захирал 2005 2008

Ердийн гишүүнд нэр дэвшигч П.Батбаяр №3

Боловсрол

- ИБУИНВУ Swansea University Эдийн засагч, бакалав
- ИБУИНВУ London Business School Санхүү магист

Ажлын туршлага

- Хаан банк. Байгууллагын банкны захирал 2014
- Интер Групп ХХК. ТУЗ-ийн дарга 2011 2014
- Scedrock Mongolia LLC, Гүйцэтгэх захирал 2010 2013
- ЕСБХБ, Лондон хот, Natural Resources Banker 2001 2010
- Сангийн яам, Эдийн засагч 2000 2001

Ердийн гишүүнд нэр дэвшигч Г.Цогбадрах №4

Боловсрол

- Монгол МУИС-ын Эдийн засгийн сургууль Банкны эдийн засагч
Бакалавр
- АНУ Үндэсний Их Сургууль Бизнес удирдлага Мастер

Ажлын туршлага

- Голомт Банк Гадаад төлбөр тооцооны нягтлан бодогч 1996 1997
- Хан Банк Санхүү, дотоод аудит, салбарын удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирал 2000 2008
- Тэнгэр Санхүүгийн Нэгдэл Хөрөнгө оруулалт хариуцсан захирал 2010 2011
- Тэнгэр Даатгал Гүйцэтгэх захирал 2011 2014
- Ард Санхүүгийн Нэгдэл ТУЗ-ийн хараат бус гишүүн 2014

Ердийн гишүүнд нэр дэвшигч С.Халиунаа №5

Боловсрол

- Их Британи Cardiff Metropolitan University Бизнесийн удирдлагын магистр
Магистр
- Монгол МУИС, ХЗС Эрх зүйч Бакалавр
- Монгол МУИС, ГХСС Багш, орчуулагч Бакалавр

Ажлын туршлага

- Ард Санхүүгийн Нэгдэл ХК Хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан захирал
2016 Одоог хүртэл
- АПУ ХК Хуулийн зөвлөх 2014 2016
- ЗГХА, ХТҮГ Хуулийн зөвлөх 2012 2014

Ердийн гишүүнд нэр дэвшигч М.Сэргэлэн №6

Боловсрол

- Монгол Улс Бизнес олон улсын дээд сургууль Нягтлан бодогч Бакалавр

- Япон Исити Коллеж Менежмент Бакалавр

Ажлын туршлага

- Техник Технологийн Дээд Сургууль Захирал 2005 Одоог хүртэл
- TCI Захирал 1999 2015
- МАС ХХК Захирал, менежер 1997 2000

Ердийн гишүүнд нэр дэвшигч Ө.Ашхүү №7

Боловсрол

- Монгол МУИС, ГСА Бүрэн дунд боловсрол Бүрэн дунд боловсрол
- Унгар Будапештын ЭЛТЭ ИС Хуульч Бакалавр
- Монгол Отгонтэнгэр ИС Компанийн эрх зүйч Бакалавр

Ажлын туршлага

- Хаан бүргэд ХХК Менежер 2003 2004
- УИХ-ын Тамгын газар Тамгын газрын ажилтан 2004 2006
- Унгар улсын өргөмжит консулын газар Унгар улсын Өргөмжит консулын газрын ажилтан 2006 Одоог хүртэл
- Блюскай Партнерс ХХК Гүйцэтгэх захирал 2010 2014

Хараат бус гишүүнд нэр дэвшигч Б.Солонго №1

Боловсрол

- ОХУ Санхүүгийн дээд сургууль Магистр
- Украин 12 дугаар дунд сургууль Ерөнхий боловсрол
- Монгол Сант сургууль Ерөнхий боловсрол

Ажлын туршлага

- Софтлайн Азия ХХК Маркетингийн менежер 2011.03 2011.09
- Софтлайн Азия ХХК Борлуулалт, маркетингийн менежер 2011.09 2012.03
- Софтлайн Азия ХХК Худалдаа, маркетинг хариуцсан захирал, Оньс рүүмын үүсгэн байгуулагч 2012.03 2015.05
- Софтлайн Азия ХХК Гүйцэтгэх захирал 2015.05 Өнөөдрийг хүртэл

Хараат бус гишүүнд нэр дэвшигч А.Азбаяр №2

Боловсрол

- Монгол Улс Санхүү эдийн засгийн их сургууль Бизнесийн удирдлагын бакалавр Бакалавр

- АНУ Виржиниагийн олон улсын их сургууль Бизнесийн удирдлагын магистр
Магистр

Ажлын туршлага

- BP LLC Гүйцэтгэх захирал 2016.05 Одоо хүртэл
- Wagelanger&Heisterkamp LLC Ахлах зөвлөх/Партнер 2010.05
2016.02
- Хойд Америк-Монголын Бизнес зөвлөл Санхүүгийн менежер 2009.12
2015.12
- Монгол Шуудан Банк Төслийн зээлийн менежер 2005.09 2007.05

Хараат бус гишүүнд нэр дэвшигч Б.Гантулга №3

Боловсрол

- ОХУ ОХУ-ын Г.В.Плехановын нэрэмжит Эдийн засгийн их Сургууль Эдийн
засагч Бакалавр

Ажлын туршлага

- Сүү ХК Гүйцэтгэх захирал 2014 Одоо хүртэл
- Анакс ХХК Гүйцэтгэх захирал 2012 2014
- Моннис Групп Дэд захирал 2009 2012

Хараат бус гишүүнд нэр дэвшигч Х.Далайбаяр №4

Боловсрол

- Монгол Төрийн дээд сургууль Сэтгүүлч Бакалавр
- Монгол Санхүү эдийн засгийн дээд сургууль Бизнес удирдлага
Магистр

Ажлын туршлага

- Солержи ХХК Гүйцэтгэх захирал 2015 Одоог хүртэл
- Croke Park Hotel Зочид буудлын албаны ахлах менежер 2009 2014
- Croke Park Hotel Ресторанд тогооч 2004 2009
- Lecriven duty free shop Менежер 1999 2003

Кумулятив аргаар санал өгөхтэй холбогдуулж, зааварчилгаа өгөв. Хувьцаа эзэмшигч та кумулятив аргаар саналаа өгөхдөө доорх зааварчилгааны дагуу өгнө үү. Саналын тоогоо илүү эсвэл буруу өгсөн тохиолдолд таны саналын хуудас хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч та “Жинст Увс” ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг бол “Жинст Увс” ХК-ийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн хараат бус гишүүн байхаар тогтоосон.

Таны эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд 900 ($100 \times 9 = 900$) болох ба үүнээс 600 саналын эрхээрээ ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болохыг анхаарна уу.

Асуулт, хариулт: байхгүй.

Хэлэлцсэн нь №4: “Жинст Увс” ХК-д “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийг нэгтгэх замаар хоёр компани нэгдэх тухай. Нэгдэх гэрээ болох хувьцаа хөрвүүлэх журмыг батлах тухай.

Танилцуулсан нь: Хурлын дарга Ч.Ганхуяг: Жинст Увс ХК нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг өөртөө нэгтгэх замаар хоёр компани нэгтгэх гэрээ, хувьцаа хөрвүүлэх журмыг та бүхэн хурлын материалаас уншиж танилцана уу. Нэгтгэх тооцоолол, төсөл мөн Жинст Увс ХК-д Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг нэгтгэх журмаас нарийвчлан танилцуулсан байгаа.

Жинст Увс ХК нь одоогоор 1,665,938 ширхэг гаргасан хувьцаатай бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг өөртөө нэгтгэснээр дараах байдалтай болох юм.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Жинст Увс ХК нь тус бүрийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг үндэслэн, талуудын ТУЗ-ийн хүлээн зөвшөөрч баталсан үзүүлэлтүүдийн дагуу Жинст Увс ХК-ийн хувьцааг нэг бүрийг 1,858 төгрөгөөр үнэлж харин Жинст Увс ХК нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааг нэг бүрийг нь 2,912 төгрөгөөр үнэлж харилцан тохиролцож байгаа бөгөөд ингэснээр нэгдэсний дараах компани **28,614,263** ширхэг гаргасан хувьцаатай болж байгаа юм.

Жинст Увс ХК-ийн 1 ширхэг хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 1.57 ширхэг хувьцаанд хөрвүүлэхийг хоёр компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөх болон Хувьцаа эзэмшигчдийн хурал харилцан хүлээн зөвшөөрч, тохиролцож байгаа бөгөөд хоёр компани нэгдэсний дараагаар нийт 28,614,263 ширхэг хувьцаатай болж байна.

Хоёр компани нэгдэх үед тус тусдаа эзэмшиж байгаа хувьцааг харилцан халаалсах төлөвлөгөөтэй байна.

Та бүхэнд дахин жишээ авч тайлбарлавал Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн нэг хувьцаа эзэмшигч 1,000 ширхэг хувьцаа эзэмшиж байсан бол хоёр компани нэгдэсний дараагаар 1,570 ширхэг эзэмшдэг болох юм. Харин хувьцааны үнийн хувьд Жинст Увс ХК-ийн хувьцааны үнэтэй ижил үнэлэгдэж байна гэсэн үг. Ийнхүү нэгдэсний дараагаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигч бүр бутархай тооны хувьцаатай үлдэж байгаа бөгөөд нэгдэсний дараагаар компани уг

бутархай хувьцааг мөнгө төлж эргүүлэн худалдан авах, мөнгө нэмж төлж бутархай хувьцаагаа бүхэлчлэх сонирхолтой хувьцаа эзэмшигчдийн хувьцааг бүхэлдэх асуудлыг шийдвэрлэнэ.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг Жинст Увс ХК-тай нэгтгэхтэй холбогдуулж ойлгомжгүй зүйл болон асууж тодруулах зүйл байвал асуугаарай. Нэгтгэхтэй холбоотой болон хувьцаа хөрвүүлэх тооцололтой холбоотойгоор та бүхэнд нэмж тодруулах зүйл байна уу?

Асуулт, хариулт: Байхгүй.

Хэлэлцсэн нь №5: Компани нэгтгэх үйл ажиллагааны тухай. Компани нэгтгэж буйтай холбогдуулж компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай.

Танилцуулсан нь: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан захирал С.Халиунаа: Хурлаар танилцуулж буй дүрмийн төсөл нь шинээр үүсгэн байгуулагдах компанийн дүрмийн төсөл бөгөөд өөрөөр хэлбэл Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг өөртөө нэгтгэхийг зөвшөөрсөн зөвшөөрөл Хорооноос гарсны дараагаар Улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгүүлж, удирдлага болгох дүрэм юм.

Та бүхэн одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа компанийн дүрмийн төсөлтэйгөө ажлын цагаар хүрч ирэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ж.Дамбаасүрэнтэй уулзан танилцаж болон бөгөөд компанийн санхүүгийн тайлангаа Монголын хөрөнгийн биржийн сайтнаас тухай бүр авах боломжтой байгаа.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг өөртөө нэгтгэх замаар хоёр компани нэгдэж байгаа бөгөөд шинээр үүсгэн байгуулагдаж буй компанийн дүрмийн төслийг батлах асуудлыг хэлэлцэж байна. Шинээр үүсгэн байгуулагдаж буй компани нь нийт 28,614,263 ширхэг гаргасан хувьцаатай байна. Дээрх дүрмийн төслийг зөвхөн хоёр компани нэгдсэний дараа, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, мөрдөж ажиллах дүрмийн төсөл болно.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм нь 18 бүлэг, 220 заалттай бол, шинэ дүрмийн төсөл нь 13 бүлэг, 174 заалттай.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрмийн зохицуулалтаар ТУЗ-ийн дэргэд:

1. Нэр дэвшүүлэх, цалин урамшуулал, засаглалын хороо;
2. Стратеги, хөрөнгө оруулалтын хороо,
3. Аудитын хороо нь үйл ажиллагаа явуулах үндсэн үүрэгтэй.

Шинэ дүрмийн төслөөр ТУЗ-ийн дэргэдэх хороодууд нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

1. Аудитын хороо,
2. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо,
3. Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулах болно.

Түүнчлэн шинэ дүрмийн төслөөр компанийн тухай хуулийн 10 болон түүнээс дээш хувь эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй бол шинэ дүрмийн төслөөр 5 болон түүнээс дээш хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй ба ТУЗ-ийн гишүүдэд тавигдаж буй шаардлага нь өндөрсгөж байгаа болно. Тухайлбал: 8.13.4-т “ТУЗ-ийн гишүүн нь өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх” зэрэг ТУЗ-ийн үүрэг хариуцлагыг өндөржүүлсэн зохицуулалттай болно.

Асуулт, хариулт: байхгүй.

Хэлэлцсэн нь №6: “Жинст Увс” ХК-ийн нэрийг “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болгон өөрчлөн батлах тухай.

Танилцуулсан нь: Хурлын дарга Ч.Ганхуяг. Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Жинст Увс ХК-д нэгдэж хоёр компани нэгдэж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулж компанийн нэр Ард Санхүүгийн Нэгдэл ХК болгох саналыг дэвшүүлж байна. Асуух асуулт, санал байна уу?

Асуулт, хариулт: Байхгүй

Хэлэлцсэн нь №7: Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх тухай

Танилцуулсан нь: Хурлын дарга Ч.Ганхуяг: Компани нэгтгэх үйл ажиллагаатай холбогдуулж, үйл ажиллагааны чиглэл; нэмэлт өөрчлөлт оруулах тухай. Одоогоор Жинст Увс ХК-ийн дүрэмд “бизнесийн зөвлөгөө” үндсэн үйл ажиллагаатай байгаа бөгөөд үүн дээр нэмж “хөрөнгө оруулалт”-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлийг нэмэх асуудлыг танилцуулж байгаа болно. Үүнтэй холбогдуулж асуух асуул байна уу?

Асуулт, хариулт: байхгүй.

Санал хураалт дуусав.

Тооллогын комиссын дарга Б.Мөнхзул: Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлаар:

Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
------------	------------	------------

Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1,665,938	100%	905,691	99%	1,665,938	100%	0	0%		100%	0	0%

2. “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” асуудлаар:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1,665,938	100%	905,552	99%	1,665,938	100%	3100	%		100%	0	0%

3. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнийг кумулятив аргаар сонгох” асуудлаар:

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1. Ч.Ганхуяг	1,304,176
2. А.Батболд	783,844
3. П.Батбаяр	780,360
4. Г.Цогбадрах	766,939
5. С.Халиунаа	759,433
6. М.Сэргэлэн	763,509
7. Ө.Ашхүү	199,277

Үүнээс ТУЗ-ийн энгийн гишүүнээр Ч.Ганхуяг, А.Батболд, П.Батбаяр, Г.Цогбадрах, С.Халиунаа, М.Сэргэлэн нар сонгогдов.

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид	Кумулятив аргаар санал өгсөн саналын эрхийн тоо
1. Б.Солонго	806,785
2. А.Азбаяр	794,537
3. Б.Гантулга	907,156
4. Х.Далайбаяр	114,242

Үүнээс: ТУЗ-ийн хараат бус гишүүнд: А.Азбаяр, Б.Солонго, Б.Гантулга нар сонгогдов.

4. “Жинст Увс ХК-д Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг нэгтгэх замаар хоёр компани нэгдэх тухай. Нэгдэх гэрээ болох хувьцаа хөрвүүлэх журмыг батлах тухай” асуудлаар:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1,665,938	100%	898,301	98%	1,665,938	100%	0	0%	1,665,938	100%	0	0%

5. “Жинст Увс ХК-д Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг нэгтгэж буйтай холбогдуулж компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938		Хуралд оролсон нийт саналын эрхтэй	

ширхэг/		/916,720 ширхэг/		ширхэг/		/916,720 ширхэг/		ширхэг/		хувьцаа /916,720 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1,665,938	100%	901,801	98%	1,665,938	100%	0	0%	1,665,938	100%	0	0%

6. “Жинст Увс” ХК-ийн нэрийг “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болгон өөрчлөн батлах тухай:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1,665,938	100%	899,801	98%	1,665,938	100%	0	0%	1,665,938	100%	0	0%

7. “Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх тухай” асуудлаар:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /1,665,938 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /916,720 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь

1,665, 938	100%	893,39 2	97%	1,665, 938	100%	0	0%	1,66 5,93 8	100 %	0	0%
---------------	------	---------------------	------------	---------------	------	---	----	-------------------	----------	---	----

Саналын эрхтэй 3,100 ширхэг хувьцаатай 8 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

Хурлын шийдвэр:

Хурлын дарга Ч.Ганхуяг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Жинст Увс ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлав.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор шийдвэрлэв.
3. Жинст Увс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Ч.Ганхуяг, А.Батболд, П.Батбаяр, Г.Цогбадрах, С.Халиунаа, М.Сэргэлэн нарыг хараат бус гишүүдээр А.Азбаяр, Б.Солонго, Б.Гантулга нарыг сонгов.
4. Жинст Увс ХК-д Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг нэгтгэх замаар хоёр компани нэгдэх тухай. Нэгдэх гэрээ болох хувьцаа хөрвүүлэх журмыг батлав.
5. Жинст Увс ХК-д Ард Санхүүгийн Нэгдэл ХЗ-ийг нэгтгэж буйтай холбогдуулж компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлав;
6. Жинст Увс ХК-ийн нэрийг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болгон өөрчлөн батлах тухай;
7. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх буюу “хөрөнгө оруулалт”-ийг нэмэх тухай асуудлыг тус тус хэлэлцэж батлав.

Хурал 16 цаг 30 минутанд дуусав.

ХЯНАСАН:

Хурлын дарга

Ч.Ганхуяг

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

Нарийн бичгийн дарга

Ж.Дамбаасүрэн